

## МОНГОЛ УЛСЫН ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН БОДЛОГО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Т.Лагнай\*  
С.Рэнцэндорж\*\*

**Хураангуй:** Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засгийн системд шилжээд 28 жил болж байна. Манай улс зах зээлийн эдийн засагт шилжихэд баримталсан гол үзэл баримтлал нь чөлөөт зах зээлийн буюу эдийн засгийн аливаа асуудлыг хувийн өмчид тулгуурласан зах зээлийн эрэлт нийлүүлэлт, үнийн механизм зохицуулна гэсэн онол юм. Гэтэл засгийн газар нь эдийн засгийн үйл амьдралд шууд оролцсоноор үр ашигт үйл ажиллагааг дэмжих бус засгийн газар зах зээлийн хооронд сул төсвийн хязгаарлалтын асуудлыг бий болгож, улмаар эдийн засгийн хөгжлийг удаашруулах, орлогын тэгш бус хуваарилалтыг улам өөгшүүлэх сул талтай.

Засгийн газрын оролцоо эдийн засгийн хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэгдэх Зүүн өмнөд Азийн орнуудын эдийн засгийн хөгжилд засгийн газар нь ямар үүрэг гүйцэтгэснийг тодруулах, мөн засгийн газар зах зээлийн хоорондын харьцаанаас бий болох сул төсвийн хязгаарлалтын асуудал гэж юу болох манай улсад байгаа эсэх, байвал ямар салбарт компани засгийн газраас тусламж дэмжлэг авч байгаа талаар тодруулах нь энэхүү судалгааны зорилго юм. Судалгааны зорилгыг тодруулахын тулд Монгол Улсын татаас санхүүжилтийн зарим асуудлыг жишээ болгон авлаа.

**Түлхүүр үгс:** татаас, сул төсөв, сул зээл, сул татаас

**Abstract:** It's been 28 years that Mongolia was changed to Free Market System from Centrally Planned Economic System. Theory behind this change in Market Economy was based on the free market system which represents that any issues relate economy would be manipulated by supply chain of personal enterprise. Unfortunately, involvement from government to personal companies business brought issues under the weak budgetary constraint, instead of market development, then economic ill and uneven revenue allocation were overly spread. .

The aim of this study is to clarify things such as: what was the effect of the government on the economic development of the Southeast Asian countries, which reportedly played an important role, and what is the weak budgetary constraint of a market intervention? Does this exist in our country, if so, which companies receive government support? Some examples of subsidies in Mongolia are emphasized to clarify the purpose of the study.

**Keywords:** subsidy, weak budgetary, weak loan, weak subsidies

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) laagii@yahoo.com

\*\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) srentsendorj@yahoo.com

### **Онолын үндэслэл: Эдийн засгийн хөгжилд Засгийн Газрын гүйцэтгэсэн үүрэг**

Зүүн өмнөд Азийн эдийн засгийн хөгжилд засгийн газрын гүйцэтгэсэн үүргийн талаар доорхи үндсэн 3 үзэл баримтлал байдаг.

1. Шинэ сонгодог онол
2. Засгийн газар хөгжлийг удирдах онол
3. Институцийн онол

Шинэ Сонгодог онолын үзэл баримтлал нь эдийн засгийн ихэнхи зохицуулалт нь зах зээлийн үнийн механизмаар дамжин зохицуулагдах ба зах зээлийн механизм хангалттай бус үед хувийн хэвшлийн зохион байгуулалтаар зах зээлийн гажуудлыг арилгана гэдэг. Засгийн газрын гүйцэтгэсэн үүрэг нь хуулийн зохицуулалтыг бий болгох, зах зээлээр бий болохгүй нийтийн эзэмшлийн барааг нийлүүлэхэд л байсан гэж үздэг. Энэ үзэл нь Дэлхийн Банкны тайланд (1991) тусгагдсан байдаг.

Нөгөөтэйгүүр засгийн газрын гүйцэтгэх үүргийг чухалчилсан үзэл баримтлал нь эдийн засгийн хөгжлийн анхан шатанд нөөцийн ашиглалт, хөрөнгө оруулалтын хуваарилалт, технологийн хоцрогдлыг зах зээлийн механизмаар зохицуулж чадахгүй (зах зээлийн гажуудал) тул зах зээлийг орлож Засгийн газрын оролцоо шаардлагатай байсан гэж үздэг. Энэ үзэл баримтлал нь Зүүн өмнөд Азийн орнуудын хүчтэй засгийн газрын оролцоо байхгүйгээр ялангуяа гүйцэтгэх засаглалын төрийн албан хаагчдын оролцоо байхгүйгээр аж үйлдвэрлэл хөгжиж чадахгүй байсан гэдэг. Гол төлөөлөгч нь С.Жонсон, Р.Ваде нар бөгөөд энэ үзэл нь улс төрчид, ард иргэдийн дунд ихээхэн хүлээн зөвшөөрөгдөх боловч эдийн засгийн ухаанд голлох байр суурь эзэлдэггүй.

Дээрхи хоёр онол нь Зүүн өмнөд Азийн хөгжилд засгийн газрын гүйцэтгэсэн үүргийн талаар бүрэн гүйцэт тайлбар өгч чаддаггүй боловч эдгээр хоёр онолыг нэгтгэсэн нь Дэлхийн Банкны судалгаа болох *"East Asian Miracle: Economic Growth and Public Policy"* (1993) болно.

Засгийн газрын гүйцэтгэсэн үүргийн талаархи 3 дахь үзэл баримтлал нь Институцийн эдийн засгийн ухааны нэг урсгал болох Институцийн харьцуулсан шинжилгээ бөгөөд Зүүн өмнөд Азийн орнуудын эдийн засгийн хөгжлийн тухай дээрхи хоёроос өөр үзлийг баримталдаг.

Институцийн харьцуулсан шинжилгээ нь эдийн засаг дахь зохицуулалтын асуудлыг зөвхөн зах зээлийн үнийн механизмаар зохицуулж чадахгүй бөгөөд зах зээлийн гажуудлыг засгийн газар арилгахад мөн л засгийн газрын гажуудал үүснэ гэж үздэг. Харин зах зээлийн гажуудлыг аж ахуйн нэгж байгууллагуудын дотоод зохион байгуулалт, тэдгээрийн хоорондын харилцаа, санхүүгийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллага хоорондын харилцаа,

үйлдвэрчний эвлэл, хөдөө аж ахуй эрхлэгчид зэрэг хувийн хэвшлийн институциуд шийдвэрлэнэ (Aoki 1996).

Институцийн онолоор бол Зүүн өмнөд Азийн орнуудын засгийн газрын гүйцэтгэсэн үүрэг нь нөөцийн хуваарилалтад шууд оролцох бус хувийн хэвшлийн институци болон институци хоорондын харилцан хамаарлыг хөгжүүлсэнд байсан. Зөвхөн зах зээл, засгийн газар гэсэн харилцан биенээ орлох хоёрхон субьект эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх бус хувийн хэвшлийн бусад институциуд ч эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэнэ гэж үзнэ.

Институцийн харьцуулсан шинжилгээний онол нь хувьслын тоглоомын онол, мэдээллийн эдийн засгийн ухааны эзэн төлөөллийн загварыг ашиглан Зүүн өмнөд Азийн орнуудын Засгийн газар хувийн хэвшлийг татвар, татаас, санхүү, аж үйлдвэрлэлтийн бодлогоор хэрхэн дэмжиж, хувийн хэвшлийн салбарыг яаж хөгжүүлсэн талаар онолын тайлбарыг өгсөн (Aoki 1996, 2001).

Мөн татвар, татаас, зээлийн бодлогоос бий болох сул төсвийн хязгаарлалтын асуудлыг хэрхэн шийдсэнийг ч эзэн төлөөллийн онолоор тайлбарласан.

Манай улс бизнесийн орчинг сайжруулах, жижиг дунд үйлдвэрлийг дэмжих бодлого явуулж байгаа өнөө үед эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг засгийн газар болон аж ахуйн нэгж байгууллагуудын хоорондын харилцаанаас бий болох сул төсвийн хязгаарлалтын асуудал гэж юу вэ? гэдгийг мэдэх шаардлагатай. Мөн энэ асуудлыг бууруулсан бусад улсын туршлагаас судласнаар урьдчилан сэргийлэх боломжтой болно. Микро эдийн засгийн онолд хэрэглэгчийн үйл хөдлөлийг тайлбарлахад төсвийн хязгаарлалт гэсэн ухагдахууныг ашигладаг. Хэрэглэгч өөрийн орлого буюу төсөвтөө тааруулан сэтгэл ханамжийг хамгийн их байлгах бүтээгдэхүүний сонголт хийнэ гэж тайлбарладаг.

Төсвийн хязгаарлалт ухагдахууныг ашиглан Харвардын Их Сургуулийн профессор Ж.Корнай нь зах зээлийн эдийн засгийн систем болон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн систем дэх байгууллагуудын үйл хөдлөл, засгийн газар ба аж ахуйн нэгж байгууллагуудын хоорондын харилцааг тайлбарласан.

Аж ахуйн нэгж байгууллагуудын төсвийн хязгаарлалт гэдэг нь компани орлогодоо тааруулан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлаа нөхнө гэсэн ухагдахуун бөгөөд “хатуу” болон “сул” төсвийн хязгаарлалт гэж ангилж болно. Сул төсвийн хязгаарлалтад сул татаас, сул татвар, сул зээл буюу сул итгэлцэл, өндөр үнийн арга гэсэн хэлбэрүүд байдаг.

Ж.Корнай нь зах зээлийн эдийн засагт байгууллагууд нь ерөнхийдөө хатуу төсвийн хязгаарлалттай үйл ажиллагаа явуулдаг гэж тайлбарласан. Зах зээлийн эдийн засагт ихэнхи байгууллага хувийн өмчид тулгуурласан тул байгууллага ашигтай ажиллах, дампуурах нь тухайн байгууллагын өмчлөгч, удирдлагаас л хамаарна. Засгийн газраас үргэлж тусламж дэмжлэг авах нь бага байдаг.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт байгууллага нь сул төсвийн хязгаарлалттай үйл ажиллагаа явуулна гэж тэрээр тайлбарласан. Улсын өмчид тулгуурласан байгууллагын оршин тогтнох, дампуурах нь байгууллагын ашиг алдагдлаас үл хамаардаг, үргэлж засгийн газраас тусламж авдаг.

**Судалгааны хэсэг: Татаас санхүүжилтийн үр нөлөө, өнөөгийн байдал хийсэн харьцуулсан судалгаа**

1990-иад он хүртэлхи төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системд манай улсын аж ахуй нэгж байгууллагууд ашиггүй ажиллаж байсан ч засгийн газраас татаас авах, буцаан төлөх үүрэггүй зээл авах, бараа бүтээгдэхүүн тогтмол үнээр зарах, татвараас чөлөөлөгддөг байсан. Үүний үр дүнд байгууллагад ашгийн төлөө үр ашигтай ажиллах, технологийн шинэчлэл хийх хөшүүрэг байхгүй байсан байна. Байгууллага болон засгийн газар хоорондын энэхүү харилцаа нь Ж.Корнайн онолын дүгнэлтийн дагуу эдийн засгийн системийг уналтад хүргэсэн. 1990-ээд оноос хойш өмч хувийн эзэмшилд очин, зах зээлийн хуулиар үр ашигтай ажиллах компаниуд л өрсөлдөөний үр дүнд үлдэж нийгмийг хөгжүүлнэ гэсэн чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн үзлийг манай улс баримтлах болсон.

Зах зээлийн эдийн засгийн системтэй өнөө үед манай улсын ихэнхи байгууллагууд хувийн өмчид тулгуурлан, ашгийн төлөө үр ашигтай үйл ажиллагаа явуулах хөшүүрэг бий болсон. Зах зээлийн хуулийн дагуу байгууллагын орлого зарлагын хамаарал өндөрссөн. Байгууллагууд хуулийн дагуу татвар төлөх үүрэгтэй. Банкны салбар нь хувийн өмчид тулгуурлах болсноор зээл нь заавал эргэн төлөгдөх нөхцөлтэй. Зээлийн төлөлт муудахад нэмж санхүүжилт өгдөггүй болсон.

Гэтэл засгийн газрын зарим бодлого болон эрх мэдэл бизнесийн хамаарлын үр дүнд тодорхой салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага болон засгийн газрын хооронд сул төсвийн хязгаарлалтын асуудал бий болсон нь ажиглагддаг. Тухайлбал, орлогоос давсан зарлагаа байгууллагууд нь засгийн газраас сул татаас, сул татвар, сул зээл хэлбэрээр нөхөж байна.

*Сул татаас* гэдэг нь байгууллагын үйл ажиллагаа доголдоход засгийн газар төсвийн хөрөнгийг /татвар төлөгчидийн мөнгийг/ тус байгууллагад тусламж хэлбэрээр өгөх хэлбэр юм.

Манай улсад шатахуун импортлогч, газар тариалан, мал аж ахуй эрхлэгч, цахилгаан эрчим хүчний салбарт ажиллаж буй байгууллагууд нь татаасыг их хэмжээгээр авдаг. 2018 онд татаас шилжүүлгийн зардалд 2,206.0 тэрбум төгрөг батлагдсанаас тайлант хугацаанд 415.3 тэрбум төгрөг төсөвлөгдөж 347.9 тэрбум төгрөгийг зарцуулж 83.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийхээс 65.8 тэрбум төгрөгөөр өсчээ. (Хүснэгт 4,5) Тайлант хугацааны татаас урсгал

шилжүүлгийн зардлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад улсын төсөвт 28.5, орон нутгийн төсөвт 17.2, хүний хөгжил сан 5.7, нийгмийн даатгалын сангийн төсөвт 23.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Хүний хөгжил сангийн зарлага 40.7 тэрбум төгрөгт хүрч, төсөвлөснөөс 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-ын 2.1-д “Хүүхдийн эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэмжлэгдсэн этгээд) эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрийн биеэр хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргах эрхтэй” гэж заасны дагуу мөнгө авах хүсэлт гаргасан хүүхдэд 63.9 тэрбум төгрөг зарцуулжээ. /Улсын их хурлын тамгын газрын хяналт үнэлгээний хэлтэсийн тайлан 2017он./

Татаасын нийтлэг шинж нь тухайн салбаруудын алдагдлыг нөхөх, үнийн өсөлтөөс сэргийлэх зорилготой. Энэ нь тухайн салбарууд дахь технологийн шинэчлэлийг дэмжихгүй, өрсөлдөх чадварыг улам бууруулах хандлагатай байна. Дээрхи салбаруудад ажиллаж байгаа байгууллагууд ч алдагдал гарахад засгийн газар алдагдлыг нөхөж өгнө гэсэн хүлээлттэй тул үр ашигтай үйл ажиллагаа явуулах хөшүүрэг сулардаг байна.

*Сул татвар* нь тодорхой компаниудыг татвараас чөлөөлөх, татварын өрийг хойшлуулах, татварын давуу эрх олгох арга. Манай улс нь татварын өршөөлийн хууль гарган татвар төлөлгүй олон жил болсон байгууллагуудад өршөөл үзүүлж байсан. Гэхдээ ямар байгууллага хэдий хэмжээний татварын өрнөөс чөлөөлөгдсөнийг нийтэд зарлаагүй.

Татварын өр хойшлогдох нь уул уурхай, барилгын салбаруудад ихээхэн ажиглагдаж байна. Жишээ нь: Хотын нийтийн тээвэрт 5,2 тэрбум, улаан буудай мах боловсруулалт-17,0 тэрбум, их дээд сургуулийн оюутны тэтгэлэгт 0,2 тэрбум гэх мэтээр олон салбаруудад 2017 онд татаас олгожээ. /Сангийн Яам. 2017 оны нэгдсэн төсөвийн товч танилцуулга/. Мөн шатахуун импорлогч компаниудийг гаалийн татвар, нэмүү өртгийн татвараас чөлөөлөх нь ихээхэн харагддаг. Энэ салбарт ч мөн сул төсвийн хязгаарлалтын татварын арга байна гэж үзэж болно. Манай улсад ихэнхи компаниуд нэмэлт санхүүжилтээ арилжааны банкны зээлээс бүрдүүлдэг. Банк санхүүгийн салбарт ашгийн төлөөх хувийн хэвшлийн банкууд ихэнхи хувийг эзлэх бөгөөд хадгаламж болон зээлийн хүүгийн хэмжээ нь чөлөөт өрсөлдөөний хуулиар тогтоогдож байгаа. Үүнээс шалтгаалан богино хугацааны өндөр хүүтэй зээл (урт хугацааны бага хүүтэй зээлийн хэмжээ бага байгаа нь зах зээлийн гажуудал гэж хэлж болно) олгогдож байгаа. Санхүүжилт авч байгаа байгууллагад үндсэн зээл болон зээлийн хүүг төлж чадах ашигтай үйл ажиллагаа явуулах, барьцаат хөрөнгөтэй байх шаардлага тавигдана. Ихэнхи байгууллагууд зээлээ буцаан төлөх үүрэгтэй бөгөөд хэрвээ төлөгдөхгүй бол барьцаат хөрөнгөөр нь зээлийн

өрийг төлүүлдэг.

**Сул зээл** буюу сул итгэлцэл гэдэг нь банкнаас олгосон зээл болон хүүгийн эргэн төлөлтийг удаашруулах эсвэл зээлийн өрийн цуцлан буцалтгүй тусламж мэт хэлбэрээр олгох зээл юм. Мөн компанийг дампуурахаас хамгаалан нэмж зээл олгох нь сул төсвийн хязгаарлалтын нэг хэлбэр болно.

Манай улсын үйлдвэрлэл болон худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй засгийн газрын эрх мэдэлтэй холбоо бүхий зарим томоохон компанийн банкнаас авсан зээлийн өрийн үлдэгдэл их боловч эргэн төлөлтийг удаашруулах, нэмж зээл авах нь нийтлэг үзэгдэл болсон. Зээлийн өрөө төлж чадахгүй компаниуд дампуурах бус зээл олгосон банк дампуурсан жишээ байна. Дашрамд дурдахад Ж.Корнай дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын шалтгаануудын нэг нь сул зээлийн хэлбэр гэж дүгнэсэн байдаг.

Мөн засгийн газраас иргэдийн хадгаламжийг хамгаалах болсноор арилжааны банкуудын үр ашигтай үйл ажиллагаа явуулах хөшүүрэг суларч эргэн төлөгдөхгүй зээл олголт улам ихсэхийг үгүйсгэх аргагүй.

Эдгээрээс манай улсад бий болсон сул төсвийн хязгаарлалтын асуудал нь:

1. Засгийн газраас эдийн засгийн асуудлыг түр хугацаанд намжаах бодлого явуулсны үр дүнд сул төсвийн хязгаарлалтын асуудал бий болсон.
2. Эрх мэдэл бизнесийн хамаарлаас болж татвар төлөгчдийн мөнгө, хадгаламж эзэмшигчдийн мөнгийг үр ашиггүй ашигласнаар сул төсвийн хязгаарлалтын асуудал үүссэн гэж хэлж болно.


Хүснэгт 1. Улсын төсвийн байгууллагуудад 2017 онд олгосон урсгал санхүүжилтын өнөөгийн байдлыг авч үзвэл: /Сая төгрөгөөр/

№	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	Жилийн дүн	
		Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Авлигатай тэмцэх газрын дарга	9,445.6	9,444.4
2	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	53,731.9	52,458.2
3	Барилга, хот байгуулалтын сайд	12,206.3	12,204.3
4	Батлан хамгаалахын сайд	164,987.7	164,936.7
5	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	1,136,871.2	1,096,274.4
6	Гадаад харилцааны сайд	61,538.5	61,116.6
7	Зам, тээврийн хөгжлийн сайд	7,750.5	7,056.3
8	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	12,324.7	12,239.9
9	Монгол Улсын ерөнхий аудитор	8,912.7	8,912.7

10	Монгол Улсын ерөнхий сайд	90,797.8	90,250.4
11	Монгол Улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	4,561.4	4,540.4
12	Монгол Улсын их хурлын дарга	29,683.1	28,924.4
13	Монгол Улсын үндсэн хуулийн Цэцийн дарга	1,595.0	1,595.0
14	Монгол Улсын шадар сайд	101,592.6	101,044.6
15	Сангийн сайд	1,612,826.5	1,604,963.5
16	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1,734.6	1,729.0
17	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	15,761.0	15,761.0
18	Төрийн албаны зөвлөлийн дарга	730.6	730.6
19	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	4,083.1	4,083.1
20	Улсын ерөнхий прокурор	26,635.0	26,635.0
21	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	14,975.8	14,975.8
22	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	2,012.5	1,957.3
23	Үндэсний статистикийн хорооны дарга	7,314.3	7,141.6
24	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,052,634.2	1,047,278.1
25	Хууль зүй, дотоод хэргийн сайд	411,768.0	410,664.9
26	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	805.6	805.6
27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	159,315.1	154,572.1
28	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	563.8	563.8
29	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	46,671.3	46,671.3
30	Эрүүл мэндийн сайд	380,491.0	378,205.4
31	Эрчим хүчний сайд	19,883.0	19,595.1
	Нийт санхүүжилт	5,454,204.6	5,387,331.6

*Эх сурвалж: Сангийн яамны мэдээллийн сан*

График 1. Улсын төсвийн байгууллагуудад 2017 онд олгосон урсгал санхүүжилтын өнөөгийн байдлын график



Эх сурвалж: Сангийн яамны мэдээллийн сан

Засгийн газар компани хооронд сул төсвийн хязгаарлалтын харилцаа удаан хугацаагаар оршин байвал компаниудад үр ашигтай үйл ажиллагаа явуулах хөшүүрэг үгүй болж эдийн засгийн үр ашигтай байдал алдагдаж эдийн засгийн хөгжлийг сааруулах, орлогын тэгш бус хуваарилалтыг бий болгох муу талтай. Тиймээс судлаачдын дунд сул төсвийн хязгаарлалтыг хэрхэн арилгах талаар олон санал байдаг ба ерөнхийд нь хоёр хувааж болно.

*Нэгдүгээрх* нь компанийн үйл ажиллагааг хатуу төсвийн хязгаартай болгож засгийн газраас компанид хандан ямар нэгэн тусламж дэмжлэг үзүүлэхгүй байх арга. Гэхдээ компаниуд дампуурснаар эдийн засгийн хөгжлийг сааруулах дам нөлөөтэй гэж үзэх судлаачид байдаг.

*Хоёрдугаарх* нь сул төсвийн хязгаарлалтын асуудлыг бүрэн шийдэж чадахгүй бөгөөд пүүсийн удирдлагатай хариуцлага тооцох (корпорацийн засаглалыг хөгжүүлэх), засгийн газрын тусламж дэмжлэгийн тоог цөөрүүлэх, мөнгөн дүнг багасгах аргууд болно. Тухайлбал Японы засгийн газар компанид татаас, татвар, зээлийн аргаар тусламж үзүүлдэг ч технологийн шинэчлэлийг бий болгох, импортыг орлуулах, экспортыг нэмэгдүүлэх шаардлага тавьдаг. Засгийн газрын шаардлагыг эс биелүүлсэн тохиолдолд компанид хариуцлага тооцон дахин дэмжлэг үзүүлэхгүй байх аргуудыг хэрэглэдэг.




Хүснэгт 2. Улсын төсвийн байгууллагуудад 2018 онд олгосон урсгал  
санхүүжилтын өнөөгийн байдлыг авч үзвэл:  
(2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар) /Сая төгрөгөөр/

№	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	Эхний 2 сар	
		Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Авлигатай тэмцэх газрын дарга	5,393.2	2,437.8
2	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	10,707.3	6,359.4
3	Барилга, хот байгуулалтын сайд	2,650.8	2,523.3
4	Батлан хамгаалахын сайд	29,227.8	29,048.0
5	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	201,801.8	188,051.0
6	Гадаад харилцааны сайд	12,404.2	11,743.1
7	Зам, тээврийн хөгжлийн сайд	1,137.8	1,137.8
8	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	2,191.9	2,190.7
9	Монгол Улсын ерөнхий аудитор	1,849.2	1,849.2
10	Монгол Улсын ерөнхий сайд	19,052.6	13,224.0
11	Монгол Улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	867.6	867.6
12	Монгол Улсын их хурлын дарга	6,096.1	5,961.4
13	Монгол Улсын үндсэн хуулийн Цэцийн дарга	241.0	241.0
14	Монгол Улсын шадар сайд	16,834.2	16,535.3
15	Сангийн сайд	300,668.9	300,409.3
16	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	487.7	487.7
17	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	150.5	150.5
18	Төрийн албаны зөвлөлийн дарга	92.8	92.8
19	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	797.6	797.6
20	Улсын ерөнхий прокурор	4,680.4	4,680.4
21	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	2,213.7	918.7
22	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	364.9	359.2
23	Үндэсний статистикийн хорооны дарга	1,387.8	1,276.4
24	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	217,026.0	214,763.8
25	Хууль зүй, дотоод хэргийн сайд	69,089.7	66,736.0
26	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	194.7	194.7
27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	39,489.1	35,322.6

28	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	80.2	80.2
29	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	8,372.9	8,372.9
30	Эрүүл мэндийн сайд	60,273.1	58,547.6
31	Эрчим хүчний сайд	3,289.8	688.9
	Нийт санхүүжилт	1,019,115.5	976,049.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээллийн сан


График 2. Улсын төсөвийн байгууллагуудад 2018 онд олгосон урсгал санхүүжилт



Эх сурвалж: Сангийн яамны мэдээллийн сан

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төсөв дээр суурилан хотын захиргаанаас жил бүр олгогдож байгаа татаас, санхүүжилтийн талаарх мэдээлэлийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл:

График 3. Улаанбаатар хотын захиргааны урсгал зардлын гүйцэтгэлын өнөөгийн байдал:




Эх сурвалж: Сангийн яамны мэдээллийн сан

Мөн нийслэлийн 2018 оны төсөвт Хотын шууд төсвийн урсгал зардлын нийт дүн 342.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны урсгал зардлын тодотгосон төлөвлөгөөнөөс 33 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн дүн байна.

Үүнд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зардал өмнөх оныхоос 5.8 хувиар өсч, 9 тэрбум болжээ. Нийслэлийн Засаг даргын захиран зарцуулдаг төсвийн нөөц хөрөнгийг 12.5 хувиар өсгөжээ. Улсын болон Улаанбаатар хотын төсвийн төлөвлөлт болон зарцуулалтыг дээрх графикаас харах боломжтойн зэрэгцээ “төрийн өмчит хувьцаат компани” гэсэн нэрийн доор эрчим хүч, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт хяналтгүй татаас санхүүжилтыг олгож байна. Төрийн өмчит компаниудын үр ашигтгүй ажиллаж байгаа, хувийн хэвшилд татаас санхүүжилтыг шууд олгож байгаа зэрэг нь улсын төсвийн татаас болон урсгал шилжүүлгийн бүлгийн зардлууд жилээс жилд нэмэгдүүлж байна. Тухайлбал 2010 оноос 2017 он хүртлэх төсвөөс төрийн өмчид компаниудад татаас санхүүжилт олгосон байдлыг харуулбал:

График 4. ТӨХК-олгосон татаас санхүүжилтын өсөлт



#### **Татаас санхүүжилтийн асуудлыг зохицуулах боломж**

Дайны дараахан Япон улсын засгийн газар нь уналтад орсон аж үйлдвэрийн салбаруудаа дахин сэргээхийн тулд цахилгаан эрчим хүч, нүүрс олборлолт, тээврийн салбарт татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас хэлбэрээр хөрөнгө хуваарилах бодлого явуулж байсан. Засгийн газрын энэ бодлого нь зах зээлийн гажуудлыг арилгаж үйлдвэрлэлийн салбарыг хямралаас гаргасан боловч компани үр ашигтай үйл ажиллагаа явуулахаас илүүтэй засгийн газрын татвар, татаасын хөнгөлөлтөд хамрагдах үйл хөдлөл ихээхэн дэлгэрч сул төсвийн хязгаарлалтын асуудал бий болсон.

Үүнээс шалтгаалан Японы засгийн газар нь татварын хөнгөлөлт, татаасын бодлого явуулахдаа зах зээлийн гажуудал болон засгийн газрын гажуудлыг арилгаж хувийн хэвшлийн институцийг хөгжүүлэхийн тулд доорхи аргуудыг хэрэглэсэн гэж үздэг (Т.Оkazi 1996).

*Нэгдүгээрт*, эдийн засгийн бодлогын зорилго нь экспортын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн. Компаниуд татвар, татаасын хөнгөлөлт авсан ч гадаадын

зах зээлд өрсөлдөх чадвартай болохын тулд үр ашигтай үйл ажиллагаа явуулах хөшүүргийг бий болсон.

*Хоёрдугаарт*, хувийн хэвشلүүдэд тархан байрлах мэдээллүүдийг эдийн засгийн бодлогодоо ашигласан. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах, бодлогын үйл явцыг хянах багт хувийн хэвшлийнхний оролцоог их болгосон. Хувийн хэвشلүүдийн мэдээллийг ашигласнаар эзэн төлөөллийн асуудлаас бий болох буруу сонголт, морал- хазардын асуудлаас зайлсхийж чадсан.

*Гуравдугаарт*, эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхдээ сул төсвийн хязгаарлалтын асуудлаас сэргийлэхийн тулд татварын хөнгөлөлт, татааст хамрагдах компанийн сонгон шалгаруулалтад олон төрлийн үзүүлэлтүүдийн шаардлага тавьж нийтэд ил тодоор шалгаруулах болсон.

*Дөрөвдүгээрт*, засгийн газраас татвар, татаасын хөнгөлөлт авахын тулд компани хоорондын өрсөлдөөнийг бий болгосон. Ингэснээр үр ашигтай үйл ажиллагаа явуулж чадах компани л татвар, татаасын хөнгөлөлт авах болсон.

Япон улсын засгийн газар нь эдийн засгийн хөгжлийг бий болгохын тулд татвар, татаасын бодлогоос гадна доорхи санхүүгийн багц бодлогыг явуулсан.

- Хадгаламжийн хүүгийн хэмжээг бага түвшинд хязгаарлах
- Зээлийн хүүгийн хэмжээг мөн бага түвшинд хязгаарлах
- Банкны зах зээлд гаднаас орохыг хязгаарлах

Эдгээр багц бодлогыг К.Мурдок, Ж.Стиглиц нар “financial restraint” бодлого гэж нэрлэсэн бөгөөд чөлөөт зах зээл бүхий банк санхүүгийн салбараас илүү үр ашигтай бодлого байсан гэдгийг баталсан (Аоки 1996). Энэхүү банк санхүүгийн багц бодлогын зорилго нь банкны салбар, үйлдвэрлэлийн салбарт рент бий болгож хувийн хэвшлийн институцийг хөгжүүлэх зорилготой байсан (рент: өрсөлдөөнт зах зээлээс олж авах орлогоос илүү орлого). Хадгаламжийн хүүг өрсөлдөөнт зах зээлийн түвшнээс доогуур түвшинд хязгаарласнаар банкны салбарт санхүүжилтийн эх үүсвэрийг хямд зардлаар олох боломжийг бий болгосон. Гэхдээ хадгаламжийн хүүгийн хязгаарлалт нь банк санхүүгийн зах зээлд гаднаас нэвтрэн орж ирэх өрсөлдөөнөөс хамгаалах бодлоготой хослох шаардлагатай. Үүний үр дүнд банкны салбарын тогтвортой байдал хангагдаж, өрхийн хадгаламж зугтахаас сэргийлж чадсан.

Зээлийн хүүг өрсөлдөөнт зах зээлээс доогуур түвшинд хязгаарлах нь компанид рент бий болгосон. Компани бага хүүтэй санхүүжилт авахын банкинд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх хөшүүрэг бий болж морал хазардын асуудлаас зайлсхийж чадсан. Мөн компани хоорондын өрсөлдөөнийг ч бий

болгосон. Банкны салбарыг гаднаас орж ирэх өрсөлдөөнөөс хамгаалсны үр дүнд банкинд компанийг хянах, зээлийн багцаа хянаж урт хугацаанд үр ашигтай ажиллах хөшүүргийг бий болгож чадсан.

Эдгээр багц бодлогын үр дүнд банк болон үйлдвэрлэгчид аль алинд нь рентийг бий болгосон. Мөн чөлөөт өрсөлдөөнт зах зээлтэй харьцуулахад бага хэмжээтэй нийлүүлэгдэх бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж зах зээлийн гажуудлыг бууруулж чадсан.

Банк нь зээлдэгч компанийг хянах, зээлийн багцын эрсдэлийг хянахын тулд хөшүүрэг шаардлагатай бөгөөд дээрхи бодлого хөшүүргийг бий болгоно. Банк хадгаламжаа нэмэгдүүлж урт хугацааны зээллэг өгөх хөшүүрэг бий болно. Чөлөөт зах зээлд байхгүй. Зээлийн хүүгийн хязгаарлалт нь үйлдвэрлэгчид рент бий болгож эзэн төлөөлийн асуудлыг бууруулдаг. Санхүүжилтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг компани банкинд гаргаж өгөх хөшүүрэгтэй. Хадгаламжийн хүү болон зээлийн хүүгийн хэмжээ зах зээлийн хуулиар тогтоогддог боловч зээлийн хүүгийн хэмжээ өндөр богино хугацаагаар олгогддог. Урт хугацааны зээлийн санхүүжилт бага хэмжээгээр хийгдэх, зээлийн эргэн төлөлт муудаж найдваргүй зээлийн хэмжээ нэмэгдэх зэрэг зах зээлийн гажуудлууд бий болсон.

Эдгээр бодлогууд нь эдийн засаг хөгжихийн хэрээр тодорхой хэмжээгээр зохицуулагдаж уян хатан байх шаардлагатай. Хөгжлийн эхэн үед хадгаламжийн хүүгийн хязгаарлалт, зээлийн хүүгийн хязгаарлалт, зах зээлд нэвтрэхийг хязгаарлах, шилжих нь зүйтэй гэж К.Мүрдок, Ж.Стиглиц нар үзсэн (Аоки 1996).

## Дүгнэлт

Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн эхэн үед байгаа манай улсын хувьд орлогын тэгш бус хуваарилат, ажилгүйдэл, байгаль орчны бохирдол зэрэг зах зээлийн гажуудал ихээхэн бий болсон. Эдгээр асуудлыг засгийн газар шийдэх ёстой гэсэн үзэл нийтийн дунд ихээхэн байгаа боловч засгийн газар ч мөн адил зарим тодорхой аж үйлдвэрийн салбар, компани хооронд сул төсвийн хязгаарлалтын асуудал гарч орлогын тэгш бус хуваарилалт, нийгмийн тогтворгүй байдлыг бий болгох зэрэг гажуудал бий болно. Тиймээс Зүүн өмнөд азийн орнуудын адил Япон улсын туршлагаас судалж эдийн засгийн асуудлыг зөвхөн зах зээлийн үнийн механизм, засгийн газар шийдэх бус бусад хувийн хэвшлийн институцийг дэмжих нь зүйтэй болов уу.

**Ашигласан материал**

- [1] Монгол Улсын Сангийн яам “Улсын төсийн байгууллагын хэтийн төлөвлөлт, бүтээгдхүцнд болон хөтөлбөрт суурилсан төсөвлөлт” 2008 он
- [2] Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага” 2013 он
- [3] Т.Цэнд-Аюуш “Компанийн засаглал”. Хэвлэлийн газар: “БИТ ПРЕСС ХХК” УБ 2010 он
- [4] Монгол банк жилийн тайлан. Он: 2014, 2015
- [5] Kornai, J. (1980a) *Economic of Shortage*. Amsterdam: North Holland.
- [6] Kornai, J. (1980b) “Hard and Soft budget constraint”, *Acta Economica* 25, pp. 231-246
- [7] <http://www.iltod.gov.mn/>
- [8] <https://www.mof.gov.mn/wp-content>